



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар A/284

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, 2016 оны 55 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Магсаржав багийн 3 дугаар гудамжны 07 тоот шинэ хаягаар Баянгол 2 дугаар гудамжны 212 тоотод байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Далхаагийн Батдорж /ЛИ70012372/-ийн эзэмшлийн 510.0 метр квадрат газрыг, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээг үндэслэн “Эрдэнийн шим” ХХК /2033771/-д шилжүүлэн, зориулалтыг орон сууцны, газрын хэмжээг мэдээллийн сангийн зургийн дагуу 610 метр квадрат болгон 5 жилийн хугацаагаар

2. Жаргалант сумын Жаргалан багийн нутаг дэвсгэр Цагдаагийн газрын баруун хойд талд шинэ хаягаар Галданбошигт 1 дүгээр гудамжны 114 б тоот байрлах, худалдаа, үйлчилгээний зориулалттай Даваасүрэнгийн Дуламсүрэн /ПЭ88012819/-ийн эзэмшлийн 32.7 метр квадрат газрыг, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээг үндэслэн Дашзэвгийн Пүрэвдаш /ПЭ88012819/-д үйлчилгээний зориулалтаар, газрын хэмжээг мэдээллийн сангийн зургийн дагуу 47 метр квадрат болгон 10 жилийн хугацаагаар тус тус шилжүүлсүгэй.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуйн нэгжүүдэд үүрэг болгосугай.

Zax A/284 Ch  
02 01404

4. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

